

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-5
1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	3-5

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
07 дугаар сарын 02-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 19 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга;

Тасалсан: Р.Батболд, О.Батнайрамдал, П.Батчимэг, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./19:22/

Нэг.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн байлцав.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын талаарх илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Р.Сэддорж: 1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 14 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 07 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
19 цаг 20 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн оройн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батсүмбэрэл, Батшугар, Бямбасүрэн, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Найдалаа, Энхцэцэг, Сэддорж нарын гишүүд, Бадамсүрэн нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Гадаад томилолттой Х.Баттулга гишүүн. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хурал хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 7 сарын 2-ны өдрийн үдээс хойших хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Хэлэлцэх асуудал дээр гишүүд байна уу? Энэ асуудал бол Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хэлэлцэх эсэх дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж эхэлье.

Ардчилсан намын бүлэг тус хуулийн төсөл дээр завсарлага авсан байсан. Завсарлагаа дуусгаж байгаагаа мэдэгдсэн тул хуралдааныг үргэлжлүүлэн явуулахаар болсон.

Завсарлагаа дуусгаж байгаа талаараа Ардчилсан намын бүлгийн дэд дарга Лодойсамбуу үг хэлье. Гишүүний микрофоныг нээе.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Энэ хуулийн төсөл маань маш түргэн хугацаанд орж ирээд гишүүд маань бас тодорхой мэдээлэл дутуу

авсан, мэдээллийг хангалттай авах шаардлага үүссэн, дээр нь олон олон судалгаануудыг хийж бас энэ нийгэм болоод энэ гишүүдийн дунд үүсээд байгаа энэ эргэлзээг бас тайлах шаардлага үүссэн. Ингээд өглөө бид завсарлага авсан. Өдөр ингээд бүлгийн удирдлагуудын түвшинд ярьж байгаад ирж байгаа нөхцөл байдал, ер нь эрчим хүчний салбарт үүсээд байгаа нөхцөл байдал, ер нь энэ хуулийн төсөлтэй холбоотойгоор байгуулагдах ажлын хэсэг дээрээ бас хэлэлцэх эсэхээ дэмжээд цаашаа ажлын хэсэг дээрээ асуудлуудаа, бодитой саналуудаа яриад явах нь зүйтэй юм байна гэж үзсэн.

Тийм учраас завсарлагаа энэ цагт дуусгаж байгаагаа илэрхийлж мэдэгдэж байна.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа.

Тиймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүн дэмжиж, 92.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүн дэмжиж, 92.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүн дэмжиж, 92.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхланг дэмжсэнээр авъя. Санал хураалт явуулж дууслаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд, гараа өргөөрэй. Бямбасүрэн, Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн танилцуулна.

Ингээд Байнгын хорооны, Чойжилсүрэн сайд Байнгын хорооны гишүүдийн гаргасан саналууд байгаа. Ажлын хэсэг дээр энэ хүчин чадлыг, байршлыг, тэр төслүүдийн нэрсийг зааж энэ хуульд оруулж, энэ ажлын хэсгийг сайн ажиллуулах хэрэгтэй байгаа. Энэ дээр яг энэ Монгол Улсынхаа эрчим хүчний энэ дутагдлыг яаралтай арилгахын төлөө бүх Улсын Их Хурлын гишүүд санаа тавьж байгаа. Энэ

дээр яг энэ байршил, нэрийг зааж, энэ хуулиараа энэ төслүүдээ хэрэгжүүлцгээе. Бүгд тодорхой байгаа. Монгол Улсын тулгамдсан энэ төслүүд бүгд тодорхой байгаа. Ийм учраас энэ дээрээ, энийг сайн шийдээрэй гэдгийг хэлье.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн Байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

19.27 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР